

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 03 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 1 удаа хуралдаж 7 асуудлыг хэлэлцлээ. Үүнд: Эрдэнэ сумыг улсын тэргүүний сум шалгаруулах болзолд нэр дэвшүүлэх тухай, Зооноз өвчнөөс нийтийн эрүүл мэндийг хамгаалах хамтарсан зөвлөл байгуулах, зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах журам батлах тухай, “Бүтээн байгуулалт- ажлын байрыг нэмэгдүүлэх жил” –ийн ажлын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн танилцуулгын талаар, Олон нийтийн “Алтай радио”-ийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай, Говь-Алтай аймаг үүсэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн хүрээнд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай гэсэн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн болно.

Говь-Алтай аймгийн Шарга сумын Баянгол багийн Сумын сайн малчин Чойжилын Түмэннастын “Төхөм тунгалагийн хүрэн” үүлдрийн хүрэн ингэнээс ихэр ботго төрж, ингэ ботголсон тухай “Айлтгал”-ыг Монгол Улсын Засгийн газрын тэргүүн, Ерөнхий сайд У.Хүрэлсүхэд аймгийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч Ж.Ганбат 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр өргөн барилаа. Айлтгал гардуулах үеэр аймгийн хаваржилт, мал төллөлт, нийгэм, эдийн засгийн болон бусад асуудлаар мэдээлэл хийж, Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Алтай нутгийн нийт зон олонд хандан мэндчилгээ дэвшүүлээд тодорхой үүрэг, чиглэл өгч ажлын амжилт хүслээ.

“Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 05/1765 дугаар албан бичгийг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газраас баталсан удирдамжийн дагуу Тонхил сумын Засаг даргын Тамгын газар болон тус сумын бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаа хуулийн хэрэгжилт, төрийн үйлчилгээ, төсөв санхүү, худалдан авах ажиллагаа, хүний нөөцийн бодлого, өргөдөл гомдлын шийдвэрлэлт “Авлигын эсрэг хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгах ажлын хэсэг 2020 оны 03 дугаар сарын 5, 6-ны өдрүүдэд ажиллалаа.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, түүний шалтгаан, зөрчигдсөн хууль тогтоомж, цаашид авах арга хэмжээ, шийдвэрлэвэл зохих асуудлын талаар санал боловсруулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай 10 заалт бүхий зөвлөмжийг Тонхил сумын Засаг дарга болон төрийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарт хүргүүллээ. Мөн тус сумд ажилласан болон цаашид авах арга хэмжээний тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 3/311 дүгээр албан бичгээр Авлигатай тэмцэх газарт танилцууллаа.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал тайлант хугацаанд 2 удаа хуралдаж, 19 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Аймгийн онцгой комисс нийт 7 удаа хуралдаж, 21 асуудлыг хэлэлцэн гамшгийн сангаас нийт 95.7 сая төгрөгийг шинэ коронавирус (COVID-19)–ээс урьдчилан сэргийлэх, эм, эмнэлгийн хэрэгсэл, амны хаалт, хувийн хамгаалах хэрэгслийн нөөцийг бүрдүүлэхэд зарцууллаа.

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/107 дугаар захирамж гарч дараах шийдвэрүүдийг гаргалаа: Үүнд: 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрөөс 03 дугаар сарын 30-ныг хүртэлх хугацаанд өмчийн хэлбэрээс үл хамааран нийт аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж байгаа 0-5 хүртэлх насны хүүхэдтэй эх мөн насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг болон жирэмсэн эхийн өдрийн ажлын цагийн үргэлжлэх хугацааг 6 цагаар буюу 10:00-17:00 цагаар тогтоох, мөн хугацаанд караоке, баар, сүм хийд, шашны холбогдолтой арга хэмжээ, бүх төрлийн тоглоомын газар, спорт заал, фитнес клубын үйл ажиллагааг түр зогсоох, зах, худалдааны төвийг 10:00-18:00 цаг, ресторан, кафе, нийтийн хоолны газрыг 10:00-19:00 цаг, хүнс, өргөн хэрэглээний барааны дэлгүүрийг 10:00-21:00 цагийн хуваарьт тус тус шилжүүлсэн ба архи, согтууруулах ундааг 10:00-17:00 цагт худалдаалж, үйлчлэх, олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдөр, Наурызын баяр зэрэг тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахгүй байх шийдвэрүүдийг гаргалаа.

Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчдын сургалтын шинэ тогтолцоо хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Удирдлагын академийн ахлан түшмэлийн багц сургалтад аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн дарга, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга зэрэг 45 удирдах албан тушаалтныг зайн хэлбэрээр хамруулж эхэллээ. Мөн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 8 албан хаагч суралцаж эхэллээ.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 193 дугаар тогтоолын дагуу Баруун бүсээс Улсын тэргүүний /загвар/ сум шалгаруулах асуудлыг хэлэлцэх бүсийн уулзалтад 2020 оны 03 дугаар сарын 20,21-ний өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн нар оролцлоо.

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2019 оны үзүүлэлтүүд, Засгийн газрын гишүүдээс аймгийн Засаг даргатай 2019 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилт, Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилт болон Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт цахим хэлбэрээр хүргүүллээ.

Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 86 дугаар тушаалаар тус аймагт томилогдон ажилласан ажлын хэсгээс ирүүлсэн зөвлөмжийн дагуу Засаг даргын Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, Төрийн албан хаагчийн цалин хөлс, бусад асуудлын талаар холбогдох баримт бичигт 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс 25-ны өдрүүдэд хяналт-шинжилгээ хийлээ. Хяналт-шинжилгээний явцад шинэчлэн батлагдсан албан тушаалын тодорхойлолтын дагуу албан тушаалын зэрэглэл нь буурч байгаа болон өөрчлөгдөж байгаа, мөн цалингийн нэмэгдэл авч байгаа албан хаагчидтай уулзаж, холбогдох асуудлыг танилцуулан тодруулга, тайлбар болон тэдний албан тушаалын зэрэглэл, хавсарсан ажлын нэмэгдэлтэй холбоотой хүсэлтийг бичгээр авч, шийдвэрлэлээ.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалтад хийх аудитын төлөвлөгөөг батлуулан, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2019 оны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 03 дугаар сарын 31-ний өдрийн Засаг даргын зөвлөлийн 9 дүгээр хурлаар хэлэлцүүлэн, мөн өдрийн 1/422 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүллээ.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр тайлант хугацаанд давхардсан тоогоор 2450 иргэн төрийн үйлчилгээг авсан байна.

Тайлант хугацаанд иргэдээс бичгээр Засаг даргад 18 өргөдөл ирсэн бөгөөд шийдвэрлэлт нь 78.3 хувьтай байна.

Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем ашиглалтад орох болсонтой холбогдуулан сумдад албан бичиг хүргүүлэн, 17 сумаас судалгаа авч нэгтгэн, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт цахимаар хүргүүлээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны сайтад Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйлчилгээний нэр төрөл, албан хаагчдын танилцуулга мэдээллийг шинэчлэн байршууллаа.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” дугаарын утсанд холбогдон мэдээлсэн 29 гомдол, санал, хүсэлтийг холбогдох байгууллагуудад төрийн байгууллагуудын нэгдсэн систем “E-OFFICE” программаар шилжүүлэн, хяналт тавьж, шийдвэрлэн ажиллалаа. Шийдвэрлэлт 69.0 хувьтай байна.

ОБЕГ-аас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан “Гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй осол гэмтэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-ний удирдамжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр салхи, шуурга, цас зудын үед хүүхдээр мал хариулуулах үед гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх анхааруулга, зөвлөмжийг боловсруулж, 18 сумын 1180 малчин өрхөд “Багц мессеж”-ээр мэдээллийг хүргүүлэн ажиллалаа.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг дарга бүрэн эрхийн хүрээнд тайлант хугацаанд нийт 163 захирамж гаргасан байна. Захирамжийн ил тод нээлттэй байдлыг хангахын тулд аймгийн албан ёсны цахим хуудас болон www.govi-altai.gov.mn сайтад байршуулан мэдээлж байна.

Шүүхийн шинжилгээний албаны ажилтан албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын А/152 дугаар захирамжаар 3.976.000 төгрөгийг шийдвэрлэлээ.

Тус аймгийн хэмжээнд 2020 онд тэмдэглэлт ойг тэмдэглэн өнгөрүүлэхээр тогтсон байгууллагуудын жагсаалтыг хавсралт хүснэгтээр гаргаж, Авлигатай тэмцэх газарт аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 3/279 дугаар албан бичгээр хүргүүлээ.

Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 24 заалтыг хяналтанд авч, хэрэгжилтийг хангуулж 2019 оны жилийн эцсийн биелэлтийг 87,5 хувьтайгаар тооцож, тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 3/284 дүгээр албан бичгээр Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэст хүргүүлээ.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” болон аймгийн “Авлигын эсрэг дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2020 оны А/164 дүгээр захирамжаар батлан сум, агентлагуудад албан бичгээр хүргүүлээ.

Архивын баримтаас иргэдийн хүсэлтийн дагуу 178 иргэнд мал тооллогын болон цалингийн лавлагаа, тушаалын хуулбар олгон Төрийн архиваас үзүүлэх төлбөрт үйлчилгээний үнийн тарифын дагуу 1795000 төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлээ.

Баян-Уул, Шарга, Хөхморьт, Алтай сумын 1970 оны иргэний үнэмлэх олголтыг 85 хуудсанд иж бүрэн нягтлан шалгалт, сэлбэн засалт хийж үдэж хавтасласан. Мал тооллого болон цалингийн 12 лавлагаа гаргалаа.

Улсын Их Хурлын болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын, орон нутгийн 2016 оны сонгууль, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн саналын хуудсыг устгах зөвшөөрөл олгох тухай албан бичгийг Архивын ерөнхий газарт хүргүүллээ.

Дэлгэр, Тайшир, Шарга, Халиун, Тонхил, Дарив, Бугат, Цээл, Цогт, Төгрөг, Гуулин тосгон, Бигэр, Чандмань сумдын Засаг даргын Тамгын газрын архив, бичиг хэргийн ажилтнууд мал тооллогын А дансны бүртгэлийн 143 хадгаламжийн нэгжийн 52347 хуудас баримтыг скайнердлаа.

Иргэний бүртгэлийн чиглэлээр: Иргэний бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд шуурхай чирэгдэлгүй, чанартай хийж цахим мэдээллийн санг эрхлэн хөтөлж тухай бүр баяжилтыг хийлээ. Тайлант сард төрсний бүртгэл-297, гэрлэлтийн бүртгэл-86, үрчлэлтийн бүртгэл-8, овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл-18, нас баралтын бүртгэл-68, шинээр олгосон иргэний үнэмлэх-208, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн бүртгэл-0, аймаг доторх шилжилт хөдөлгөөн-0, иргэд, албан байгууллагад олгосон лавлагаа-1138 тус тус хийгдэж, мэдээллийн санд 1897 ХААТР маягт оруулсан байна. Мөн Улсын бүртгэлтэй холбоотой хуулийн талаарх брошур, гарын авлагыг хийлгэж иргэдэд тараан, үйлчилгээний зааланд байрлуулан мэдээлж байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр: Иргэд хуулийн этгээдийн Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 183 мэдүүлэг хүлээн авч 179 мэдүүлэг шийдвэрлэлээ. Үүнээс газраас бусад үл хөдлөх болон газар өмчлөх эрхийн хөрөнгө анх удаа өмчлөх эрхийн 32, бусад эрхийн бүртгэл 147, өмчлөх эрхийн 77 гэрчилгээ олголоо.

Иргэд хуулийн этгээдээс бүртгэлийн үйлчилгээний хураамжаар 2178359 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжаар 100667 төгрөг, татварын орлогоор 6847400 төгрөг, нийт 9126426 төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр: Хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд шуурхай чирэгдэлгүй, чанартай хийж цахим мэдээллийн санг эрхлэн хөтөлж тухай бүр баяжилтыг хийлээ. Тайлант хугацаанд 15 бүртгэл шинээр хийгдэж, дахин гэрчилгээ авах бүртгэл 26, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулсан-3 хийгдсэн бөгөөд улсын болон орон нутгийн төсөвт 575000 төгрөгийг төвлөрүүллээ.

Хяналтын чиглэлээр: Иргэдээс ирүүлсэн 20 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн ба хугацаа болоогүй 4 өргөдөл байна. Шийдвэрлэлт 80.0 хувьтай байна. Тайлант хугацаанд бүртгэлийн нийт хяналт шалгалтыг 234 удаа хийж, Иргэний бүртгэлийн чиглэлээр 4921, Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 35, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 30, нийт 5016 бүртгэл шалгалаа. Илрүүлсэн нийт зөрчил 223, шалгалтын явцад шийдвэрлэсэн зөрчлийн тоо 223, захиргааны хариуцлага ногдуулсан 204 иргэн байна. Нийт 3560000 төгрөгийн торгууль ногдуулаад байна.

Хүлээн авч шалгасан гомдол, мэдээлэл: 2020 оны эхний 03 дугаар сард гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 290 гомдол, өргөдөл мэдээлэл хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн шинжтэй 105, зөрчлийн шинжтэй 185 гомдол, мэдээлэл байна. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 290 гомдол, өргөдөл, мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 89 буюу 23,5 хувиар буурсан байна.


Гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 259 буюу 95 хувийг хуулийн анхны хугацаанд шийдвэрлэлээ.

Бүртгэгдсэн гэмт хэрэг: 2020 оны эхний 03сард аймгийн хэмжээнд төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмч хөрөнгөнд 393.9 сая төгрөгийн хохирол учирсан 37 гэмт хэрэг үйлдэгдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 58 хэргээр буюу 61,1%-иар буурч, учирсан хохирол 234.4сая төгрөгөөр буюу 2.5 дахин өссөн үзүүлэлттэй байна.

37 гэмт хэрэгт нийт 19 хүн холбогдож, гэмт хэргийн улмаас 2 хүн нас барсан, 8 хүн гэмтсэн байна.

Үзүүлэлт	2019 оны эхний 03 сард	2020 оны эхний 03 сард	Өсөлт бууралт	
			Тоогоор	Хувиар
Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэрэг	9905	8003	-1902	19,2 %-иар буурсан
Орон нутагт бүртгэгдсэн нийт гэмт хэрэг	3239	2743	-496	15,3%-иар буурсан
Говь-Алтай аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг	95	37	-33	61,1%-иар буурсан

Хэргийн ангилалаар: Хөнгөн гэмт хэрэг 24 бүртгэгдсэн нь 53 нэгжээр буюу 69 хувиар, хэрэг бүртгэлтийн хэрэг 34 бүртгэгдэж 54 нэгжээр буюу 61,3 хувиар, хүнд гэмт хэрэг 13 бүртгэгдсэн нь 5 нэгжээр буюу 28%-иар, мөрдөн байцаалтын хэрэг 3 бүртгэгдэж 4 нэгжээр буюу 57,2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.




Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлэглэлээр нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан үзвэл:

Нийт гэмт хэрэг	2019 оны	2020 оны	Гэмт хэргийн өсөлт, бууралт


	эхний 03 сар	эхний 03 сар	тоо	хувь
 Хүний амьд явах эрхийн эсрэг	5	2	-3	-60% 
 Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг	25	7	-18	-72 % 
 Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	0	0	-	-
 Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	0	0	-	-
 Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг	0	0		
 Эрүүл мэндийн эсрэг	0	0		
 Хүүхдийн эсрэг	0	0		
 Өмчлөх эрхийн эсрэг	54	25	-29	-54% 
 Үүнээс: Хулгайлах	23	12	-11	-48 % 
 Үүнээс: Хувийн өмчийг хулгайлах	19	11	-8	-42,1 % 
 Үүнээс: Автотээврийн хэрэгсэл хулгайлах	1	1		
 Үүнээс: Халаасны хулгай	0	0		
 Үүнээс: Галт зэвсэг хулгайлах	0	0		
 Дээрэмдэх	2	0	-2	2 дах 
 Залилах	20	1	-19	-95 % 
 Хөрөнгө завших	1	3	2	3 дах 
 Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших	2	0	-2	2 дах 
 Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх	0	0		
 Автотээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч явах	0	0		

	Эд хөрөнгийг устгаж гэмтээх	0	0		
	Бусдын эд хөрөнгийг устгах, гэмтээх, үрэгдүүлэх	0	0		
	Мал хулгайлах	6	9	3	50% ↑
	Эдийн засгийн	0	0		
	Үндэсний аюулгүй байдлын эсрэг	0	0		
	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	0	0		
	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	0	0		
	Авлигын	6	1	-5	-83,3% ↓
	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	2	0	-2	2дах ↓
	Хүрээлэн байгаа орчны эсрэг	1	1	-	-
	Соёлын өвийн эсрэг	0	0		
	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	0	0		
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	2	1	-1	-50% ↓
	Цэргийн албаны эсрэг	0	0		
	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайны эсрэг	0	0		


Гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж буй гэмт хэргийн төрөл



Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал: Гэмт хэргийн үйлдэгдсэн байдлаас үзэхэд согтуугаар үйлдэгдсэн хэрэг өөрчлөлтгүй, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 2,3 дахин, гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2 дахин өсч, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 64 хувиар, хүүхэд оролцсон гэмт хэрэг 80%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



Гэмт хэргийн илрүүлэлт: Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 35,3 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14,8 нэгжээр өссөн үзүүлэлттэй байгаа ба Улсын дунджаас 3,8 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.



Хэрэг бүртгэлтийн хэрэг: Хэрэг бүртгэлтийн 34 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 54 хэргээр буюу 61,4 хувиар буурч, үүнээс 12 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6 нэгжээр буюу 33,3%-иар буурсан байна.


Гэмт хэрэгт холбогдогч: Гэмт хэрэгт 19 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 хүнээр буюу 10 хувиар буурсан бөгөөд үүний 2 буюу 10,5хувийг эмэгтэй хүн

эзэлж байна. Хүйсийн харьцаанаас үзэхэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад эмэгтэй хүн 5-аар буюу 71,4%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн хохирогч, хохирлын хэмжээ: Гэмт хэргийн улмаас 37 иргэн хохирогч, үүнээс 2 хүн нас барж, 8 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн 1 буюу 33,3%, гэмтсэн хүн 15 буюу 65,2 хувиар тус тус буурсан байна.



Учирсан хохирол: Иргэн, хуулийн этгээдэд 393.9 сая төгрөгийн хохирлын 219.2 сая төгрөг буюу 55,7 хувийг нөхөн төлүүлээд байна.



Зөрчил: Нийгмийн хэв журам зөрчсөн 4542 зөрчил илрүүлэн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 910 буюу 25,1 хувиар, 4518 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 898 буюу 24,8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зөрчил гаргасан 4424 иргэнийг 132560.3 мян төгрөгөөр торгох, 40 хүнийг баривчлах, 53 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Нийт зөрчлийн 132 буюу 2.9 хувь нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зөрчил үйлдсэн байна. Согтуугаар үйлдэгдсэн зөрчил өмнө оны мөн үеийнхээс 26 буюу 24,5 хувиар өссөн байна.

Зөрчлийн хэргийн талаар: 2020 оны эхний 03 сарын байдлаар нийт 81 зөрчилд зөрчлийн хэрэг нээж шалгаснаас 14 хүнийг 3000.0 мянган төгрөгөөр торгож, 3 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 40 хүнийг баривчилсан болно.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 4524.2 сая төгрөг, Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 3526.2 сая төгрөгийг тус тус хуваарийн дагуу бүрэн авч, төсвийн байгууллагуудад санхүүжилтийг хуваарийн дагуу бүрэн олголоо.

Аймгийн төсвийн зарлага 3 дугаар сарын байдлаар 6892.2 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 6442.2 сая төгрөгийн буюу 93,4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Үүнд: Орон нутгийн төсвийн 3436,0 сая төгрөг буюу 96.9 хувийн, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 2956.2 сая төгрөг буюу 90.7 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Засгийн газрын 2020 оны 78 дугаар тогтоолд бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор эдийн засгийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний нэг болох төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан бүх шатны төсвийн шууд захирагч нарын төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэн ажиллаж цалин, тэтгэврээс бусад зарлагыг эрэмбэ дараатайгаар санхүүжүүлж байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Алтай хотын ногоон байгууламжийг шинэчлэх, өргөтгөх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, Алтай хотын гэр хорооллын өрхийг 2 тарифт цахилгааны тоолуураар хангах барааны, Алтай сум болон Бугат сумын Тахийн талд онгоц хөөрч буух зурвас байгуулах ажлын, Алтай хотын гэр хороололд явган хүний зам тавих ажлын, Хантайширын нурууны Сэрвэнгийн орой чиглэлд 6 кВ-ын ЦДАШ, дэд өртөөний хамт барих ажлын, Төнхил сумын Алтансоёмбо багийн цахилгааны эх үүсвэрийг өргөтгөх ажлын, Эрдэнэ сумын ундны усны зөөврийн автомашин нийлүүлэх барааны, Марал-Алтай өрхийн эмнэлгийн гадна тохижилтын ажлын, Тайшир сумын Галуут багт хөв байгуулах ажлын, Баян-Уул сумд хөв байгуулах ажлын, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Алтай” чуулгын хуучин барилгыг “Багшийн хөгжлийн ордон” болгож өөрчлөх ажлын, Есөнбулаг сумын 1 дүгээр сургуулийн барилгын их засварын ажлын, Алтай сумын Соёлын төвийн барилгын засварын ажлын, Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн барилгын засварын ажлын, Япон Улсын Засгийн газрын “Өвсний үндэс төсөл”-ийн хөрөнгөөр Есөнбулаг сумын 3 дугаар сургуулийн хичээлийн байрны их засварын ажлын, нийт 16 ажлын тендерийг зарлалаа.

Мөн Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Хилийн цэргийн застав, харуулын постуудад 12 мотоцикл нийлүүлэх барааны тендер болон захиалагчийн хяналтын зардлаар Засаг даргын Тамгын газрын автомашин нийлүүлэх барааны тендерийг тус тус дахин зарлалаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Нэгдсэн эмнэлгийн хатуу эдлэл нийлүүлэх барааны, Газар тариалангийн машин техник төхөөрөмж-“Ковш 30” нийлүүлэх барааны тендер тус тус үнэлгээний шатандаа байна.

Орон нутгийн өмчит 166 байгууллагын 2019 оны жилийн эцсийн өмчийн тайланг нэгтгэн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт албан бичгээр хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх Есөнбулаг сумын цахим хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэх болон Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх Цагдаагийн газрын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг тус тус сонгон шалгаруулж, шалгарсан 7 ХХК-д гэрээ байгуулах эрх олгож, үнэлгээний зөвлөмжийг захиалагчид хүргүүллээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 75-р тогтоолын дагуу дахин дуудлагын худалдааг зохион байгуулж орон нутгийн төсөвт 5.4 сая төгрөгийг төвлөрүүлэхээр шийдвэрлэлээ.

ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр: Аймгийн аюулгүй нөөцийн өвс тэжээлийг олгох талаар онцгой комиссын хурлаар хэлэлцэн, шийдвэрлэж, 1 боодол өвсийг 6.0 мянган төгрөг, 1 уут тэжээлийг 10.0 мянган төгрөгөөр худалдахаар хямдруулж, 2840 уут тэжээл, 1028 боодол өвсийг малчдад олголоо.

Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнын тодотгох судалгааг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэхээр аймгийн Засаг даргын 2020 оны А/153 тоот захирамж гарган ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 1517,1 мянган толгой эх мал төллөхөөс 3 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар 328,2 мянган толгой эх мал төллөж 326,8 мянган төл бойжиж, төл бойжилт 99,6 хувь, мал төллөлт 21,5 хувьтай байна. Том малын зүй бусын хорогдол 4,0 мянган толгой буюу нийт малын 0,1 хувийг эзлэж байна.

Газар тариалан, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр: Бүх сумдаас 2020 оны тариалалтад шаардагдах үр, техникийн захиалгыг авч нэгтгэн ХХААХҮЯамны Газар тариалангийн хөгжлийн бодлогыг зохицуулах газарт, төмс, хүлэмжний ногооны захиалгыг Элит үр ХХК-д тус тус албан бичгээр хүргүүллээ.

Аймагт төмсний үр үржүүлэх аж ахуйн нэгжийг сонгох эдийн засгийн тооцоолол, үрийн төмс олгох гэрээний төслийг боловсруулаад байна.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/449, А541 тоот тушаалын дагуу аймагт “Зооноз өвчнөөс нийтийн эрүүл мэндийг хамгаалах хамтарсан зөвлөл”-ийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 25 дугаар тогтоолоор байгуулан, уг тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

МАЛ ЭМНЭЛГИЙН ЛАБОРАТОРИ:

Говь-Алтай аймгийн мал сүрэгт шүлхийн тандалт шинжилгээ хийх ажил гүйцэтгэх гэрээг Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторит, аж ахуй нэгжүүдийн судалгааг Мал эмнэлгийн хүрээлэнд тус тус хүргүүллээ.

Бигэр сумын 1 нохойнд галзуу өвчний, мөн сумын адууны цус, дотор эрхтэн болон ходооны агуулагдахууны дээжээс боом өвчний үүсгэгч шинж тус тус илэрч, тус сумд аймгийн Засаг даргын А/21 дүгээр захирамжаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилон, хорио цээрийн дэглэм тогтоон адуу үхсэн газрын бэлчээрийн 19.5 мянган м² талбай, 21 өрхийн хашаа хорооны 40,5 мянган м² талбай, нийт 60,0 мянган м² талбайг ариутгал халдваргүйтэл хийлээ.

Төвд үйл ажиллагаа явуулж байгаа 15 цайны газрын 975 кг махны 11 дээжид Мал эмнэлгийн ариун цэврийн магадлан шинжилгээ хийж гэрчилгээ олголоо.

МАЛ АМЪТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБА: Цаг үеийн мэдээллийг сумдаас авч нэгтгэн МЭЕГ-т nyamkhuu@vet.gov.mn, tsetsegjargal@vet.gov.mn цахим хаягаар хүргүүллээ.

МЭЕГ-ын гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөө хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу мал, амьтны гоц халдварт өвчний яаралтай дуудлага гарсан үед ажиллах шуурхай багийн бүрэлдэхүүний төлөвлөгөөг батлан, мөрдөж ажиллаж байна.

Малын сэг зэмийг устгах, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах, Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, мал, амьтны шилжилт, хөдөлгөөнийг хязгаарлах тухай аймгийн Засаг даргын А/139, А/147, А/148 дугаар захирамжуудыг гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Биокомбинат” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраас боомын вакцин 18 литрийг авч, Бигэр сумын мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид хүлээлгэн өгч ашиглаж байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 4-ний өдрийн “Мал эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын нэгдсэн удирдамж”-ийн болон 3 дугаар сарын мэдээг сумдын мал эмнэлгийн тасгуудаас авч нэгтгэн Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал эмнэлгийн эрсдлийн үнэлгээний газрын meheug@vet.gov.mn, МЭЕГ-ын eruulmend@dvab.gov.mn цахим хаягаар тус тус хүргүүлээ.

ТАВ. БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Тайлант хугацаанд 46 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхтэй холбоотой мэдээллийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэн 13 иргэн, 11 аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээг гаргаж, улсын бүртгэлийн хэлтэст 40 иргэн, аж ахуйн нэгжийн газрын гэрчилгээнд Э-дугаар авах мэдүүлэг хүргүүлэн ажиллалаа.

Кадастрын зургийн лавлагаа мэдээллээр 33 иргэн, аж ахуйн нэгж байгууллага мэдээлэл авсан байна.

Аймгийн хэмжээнд газар эзэмших 12457 хүчинтэй нэгж талбар байгаагаас 2020 онд 12102 нэгж талбарын ногдуулалтыг хийж, 8330 нэхэмжлэх үүсгэн татварын ерөнхий газарт “ХУР” мэдээллийн сангаар дамжуулан 4216 иргэн, ААНБ-т нэхэмжлэх хүргүүлэн ажилласан ба аймгийн төсөвт 29.4 сая төгрөг, сумын төсөвт 9.7 сая төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна.

Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар олголтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх мэргэжлийн техникийн зөвлөл байгуулагдан, үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн хэмжээний орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн санг шинэчилж байна.

Улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөж буй “Хүйсийн говь” байгалийн нөөц газар, “Хантайширын нуруу” байгалийн цогцолбор газрын мэдээллийн давхцалыг маягт 5-ын дагуу гарган хавсралтаар хүргүүлээ. “Хүйсийн говь” газрын 854192 га газрыг байгалийн нөөц газрын ангиллаар Улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн ба 1235 нэгж талбар давхцаж байгаа бөгөөд эрх зүйн харилцаа 702 нэгж талбар 836.58 га газарт үүссэн байна.

Хантайширын нурууны 152741 га газрыг байгалийн цогцолбор газрын ангиллаар Улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн ба 252 нэгж талбар давхцаж байна. Үүнээс эрх зүйн харилцаа 189 нэгж талбар 31.84 га газарт үүссэн байна.

Аймгийн Засаг даргын А/70 дугаар захирамжаар 4 нэгж талбар газарт дуудлага худалдааг газрын цахим биржийн системээр зохион байгууллаа.

Барилга хот байгуулалтын чиглэлээр:

Жаргалан сумын Хүнхэрийн амралтын газрын байрны засварын хэмжилт, Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн тасгийн ариун цэврийн байгууламжийн засварын хэмжилтийг хийсэн ба сумдын бага оврын халаалтын зуухны судалгаа, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн инженер, мэргэжилтэй ажилчдын мэдээллийг тус тус гарган барилгын хөгжлийн төвд хүргүүлээ. Мөн 2019 оны нийгмийн дэд бүтцийн мэдээллийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хот байгуулалтын кадастрын хэлтэст, Есөнбулаг сумын тохижилт, ногоон байгууламжийн мэдээллийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт, Алтай хотын үерийн далан байгууламж барих 2 дугаар ээлжийн ажлын тоо хэмжээг

шилжүүлэн өөрчлөлт оруулах тухай саналыг БХБЯ, Барилгын хөгжлийн төвд, тус тус албан бичгээр хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 12, 28 айлын 2 орон сууцны барилгыг 3 дугаар сард ашиглалтад хүлээн авлаа.

НҮБ-ийн хүүхдийн сангаас хэрэгжүүлж буй “Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөр”-ийн хүрээнд 2020 онд хийгдэх Гуулин тосгоны сургууль, Хөгжилтэй андууд зуслан, Баянтоорой тосгоны эрүүл мэндийн төв, Баян-Уул сумын сургуулийн дотуур байрны гадна ариун цэврийн байгууламж, Алтай, Дарив сумдын ундны усны худагт ухаалаг төхөөрөмж, хайс хамгаалалт хийх, Төгрөг, Есөнбулаг, Шарга сумдын ундны усны худгийн барилга, ухаалаг төхөөрөмж суурилуулах, тохижилтын ажил хийх, нийт 9 ажлын даалгавар, 4 ажлын төсвийг тус тус гаргалаа.

Цэнгэлдэх хүрээлэнгийн зургийг мэргэжлийн байгууллагаар хянуулж, улсын байцаагчаар дүгнэлт гаргуулж, төсөвт өртгийн тооцоог хийсэн.

Нийтийн аж ахуйн чиглэлээр: 2020 оны 03-р сард манай байгууллага нь үйл ажиллагаандаа 3 гүний худаг, 2 нөөцийн худагтайгаар үйл ажиллагаагаа явуулж Алтай хотын ард иргэддээ 36262 м3 ус олзворлон түгээлээ. Насос станцын хлоржуулах төхөөрөмжөөр 3 удаагийн хлорыг 3.6 кг гипохлороор цэвэр усанд тавьж ажиллалаа. Цэвэрлэх байгууламж нь энэ сар 31331 м3 бохир усыг өөрийн картандаа хүлээн авч цэвэршүүлсэн бөгөөд 6.3 м3 усанд уусаагүй хольц буюу овор хэмжээ ихтэй хог хаягдлыг татан зайлуулж хогийн талбайд хаясан.

2020 оны 03-р сарын байдлаар байгууллагын техникийн нөхцөл олгох комисс хуралдан комиссын 03-р сарын 25-ны өдрийн 04 тоот хурлын протоколыг үндэслэн 2 иргэний 12 айлын орон сууцны 8.4 м3/хон, 3500 суудалтай цэнгэлдэх хүрээлэнгийн 30.1 м3/хон хүчин чадал бүхий шугам сүлжээний техникийн нөхцөлийг тус тус олголоо.

Халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор цэвэр ус түгээх усан сан болон ус түгээх байруудыг жавелионы уусмалаар ариутгал халдваргүйжүүлэлтыг долоо хоног тутам 2 удаа, нийтдээ 6 удаа хийлээ.

Цэвэрлэх байгууламжийн тунгаагуурын лагийг хөрс, шороо, орчинг бохирдуулах нөхцөлтэй байгаа тул дараах байдлаар халдваргүйжүүлэх арга хэмжээг авлаа.

2020 оны 3 дугаар сард аж ахуй нэгж албан байгууллагын орлого 76.0 сая төгрөг, орон сууцны орлого 24.0 сая төгрөг, ус түгээх усан сангийн орлого 2.5 сая төгрөг, зөөврийн орлого 2.7 сая төгрөг, нийт 105.2 сай төгрөгийн орлоготой ажиллалаа.

ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс хүүхдийг өөрийн биеэр ирүүлэлгүйгээр холбогдох бичиг баримт, нотолгоонд тулгуурлан 2 удаа хуралдаж шинээр 1 хүүхдийн хөгжлийн бэрхшээл, 3 хүүхдийн байнгын асаргааг тогтоон, 19 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн хугацааг сунгаж эрүүл мэнд, боловсрол, нийгмийн асуудлыг шийдвэрлэлээ.

НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлдэг "Хүүхдэд ээлтэй орон нутаг" хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохицуулах зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг танилцууллаа.

Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар Нэгдсэн эмнэлэгт 99.9 сая төгрөгийн зөөврийн дижитал рентген аппарат нийлүүлэгдлээ.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт 2019 онд шинээр нэвтрүүлсэн дэвшилтэд техник технологи, 2020-2021 онд оношилгоо эмчилгээнд шинээр нэвтрүүлэхээр судалж буй дэвшилтэд техник технологийн судалгааг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүллээ.

Эрүүл мэндийн газарт дараах хөрөнгө оруулалт хийгдлээ.Үүнд:

- ЭМС-ын 2020 оны А/108 дугаар тушаалаар нийт 12.5 сая төгрөгийн мөсөн ханатай хөлдөөгч 3, тог тогтворжуулагч 3, хэм хяналтын хэрэгсэл 3 ширхэг
- Нийт 3.8 сая төгрөгийн хэм хяналтын хэрэгсэл 39 ширхэг
- ЭМС-ын 2020 оны А/136 дугаар тушаалаар 5 нэр төрлийн 43.2 сая төгрөгийн хамгаалах хэрэгсэл
- Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/191 дүгээр тушаалаар нийт 68.9 сая төгрөгийн 5 хүртлэх насны хүүхдийн амьсгалын замын халдварын эмчилгээнд хэрэглэх 13 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмж, анхан шатны тусламжийн цүнх, эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгдлээ.
- ДЗМОУБ-аас 2.7 сая төгрөгийн зайнаас халуун хэмжигч, гар ариутгагч, сурталчилгааны материал хэвлүүлэх санхүүжилт олголоо.

Эрүүл мэндийн яамны ажлын хэсэг тус аймагт ажиллаж, “COVID-19” халдварын үед тусгаарлан оношлох болон тусгаарлан ажиглах байрны бэлэн байдалд үнэлгээ хийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгууллаа.“COVID-19” халдварын урьдчилан сэргийлэлт, бэлэн байдлын хангалт, эмч мэргэжилтнүүдийн мэдлэг, дадлыг үнэлэх дэмжлэгт хяналт, үнэлгээг нэгдсэн эмнэлэг, өрхийн 3 эрүүл мэндийн төв, ортой хувийн хэвшлийн “Машид-Эрдэнэ”, “Энхийн зуун” эмнэлэгт хийж, зөвлөгөө мэдээлэл өглөө.Чадавхжуулах сургалтыг 15 хүний бүрэлдэхүүнтэй 4 ээлжээр хичээллүүлж, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Нэгдсэн эмнэлэг, өрхийн Эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн төвийн нийт 60 хүн хамрагдлаа.

Коронавирусын халдвар (COVID-19)-аас сэргийлэх, эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангах чиглэлээр 2020 оны 03 дугаар сарын 04, 05-ны өдрүүдэд нийт 20 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэдээлэл хийлээ. Үүнд: Нэгдсэн эмнэлгийн холбогдох албан тушаалтнууд, тасгийн эрхлэгч нар нийт 13 хүн, Уламжлалт анагаах ухааны төв, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн холбогдох албан тушаалтнууд, тасгийн эрхлэгч нар нийт 8 хүн оролцлоо.

Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотой гамшгийн сангаас нийт 66.9 сая төгрөгийн санхүүжилтийг авса бөгөөд уг сангийн хөрөнгөөр 18 нэр төрлийн 22.3 сая төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 3 нэр төрлийн 12.3 сая төгрөгийн хамгаалах хэрэгслийг худалдан авч, Эрүүл мэндийн яамнаас 15 нэр төрлийн 4.9 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хуваарилагдсаныг татан авч тус, тус нөөцөллөө. Мөн хамгаалах хэрэгсэл, ариутгалын бодис нийлүүлэхээр 9 эмийн сантай гэрээ байгууллаа.

Дорноговь аймагт шинээр алтны уурхай нээгдэн үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбогдуулан сумдаас тус уурхайд ажиллаж байгаад хөл хорио тогтоосны улмаас буцан ирж байгаа иргэдийн судалгааг авах албан бичгийг харьяа байгууллагад хүргүүллээ.

“COVID-19” халдвараас сэргийлэхэд нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах зорилгоор Эрүүл мэндийн яамнаас олгосон 4.988.630 төгрөгийн 8 нэр төрлийн 4677 ширхэг хамгаалах хувцас хэрэгсэл, 4 нэр төрлийн 42 ширхэг халдваргүйтгэлийн бодис, аймгийн гамшгийн сангийн нөөцийн 10.733.800 төгрөгийн 7 нэр төрлийн 5629 ширхэг хамгаалах хувцас хэрэгсэл, 3 төрлийн 29 литр, 240 ширхэг халдваргүйтгэлийн бодис, 1 төрлийн 56 ширхэг эмнэлгийн хэрэгслийг Эрүүл мэндийн газрын даргын А/12 дугаар тушаалаар харьяа 28 эрүүл мэндийн байгууллагад хуваариллаа.

Давсны мэдээлэл, сурталчилгааны 7 хоногийн аяны хүрээнд 20121 хүнд сурталчилгаа хийж, 1910 ширхэг сурталчилгааны материалыг түгээлээ. Мөн Эрүүл мэндийн газрын болон

сумдын Эрүүл мэндийн төвийн цахим хуудсаар 900 мэдээлэл сурталчилгааг дамжуулж, 28121 хандалт авсан байна.

Орон нутгийн “Миний нутаг” телевизээр “Давсны хэрэглээг бууруулах”, “COVID-19” халдвараас сэргийлэх” сэдвээр мэдээлэл өглөө.

Тархвар судлалын 2020 оны 13 дугаар долоо хоног буюу 03 дугаар сарын 30-ны байдлаар аймгийн хэмжээнд амбулаториар 2444 үзлэг хийснээс 53 буюу 2.2% нь, яаралтай тусламжийн 166 дуудлага хүлээн авч үйлчилснээс 15 буюу 9% нь томуу томуу төст өвчин бүртгэгдлээ. Томуугаар өвчлөгсдийн 83% нь 15 хүртэлх насны хүүхэд байгаагийн 70.4% нь 4 хүртэлх насны хүүхэд эзэлж байна. Нэгдсэн эмнэлгийн 28 ортой хүүхдийн тасагт 18 хүүхэд хэвтэн эмчлүүлж байгаагаас 5 буюу 27.7% нь томуу, томуу төст өвчний шалтгаантай байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-ийг байгуулан зөвлөмж, арга зүйгээр ханган ажиллалаа. Хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Засаг даргын албан даалгаврыг гаргаж, байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна

Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хугацаагаар хязгаарласантай холбогдуулан хүүхдийг ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын 0-5 хүртэлх насны хүүхэдтэй албан хаагчийн судалгааг гарган богиносгосон цагаар ажиллуулж байна.

Дэлхийн улс орнуудад шинэ төрлийн коронавирус дэгдсэнтэй холбогдуулан халдвар авах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх” ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллаа.

Шинэ коронавирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдал, болзошгүй осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дэмжлэг тусалцаа, үйлчилгээ үзүүлэх зорилгоор 6 төрлийн гарын авлага, боршур, зөвлөмж, сэрэмжлүүлэг 3000 ширхэгийг хэвлэн гаргаж, иргэдэд түгээж халдвар, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, улсын болон орон нутгийн шийдвэрийг хэрэгжүүлэн аюулгүй байдлыг ханган ажиллахыг уриалаа.

Коронавирус, томуу, томуу төст өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, дархлаа дэмжих зорилготой витаминжуулалтын аяныг зохион байгууллаа.

“ХҮҮХЭД – ЭРХЭМ ХЭРЭГЛЭГЧ” аяныг хөл хорионы хугацаанд улс орон даяар зохион байгуулж байгаатай холбогдуулан тус аяны хүрээнд байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-өөр дамжуулан хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 18 сум, 2 тосгоны төрийн байгууллагуудад хүргүүлээ.

Өсвөр үе, хүүхэд, залуучуудыг нийгмийн өмнө хүлээх хариуцлага, хуулиар олгогдсон эрх үүргээ ухамсарласан иргэн болоход нь дэмжлэг үзүүлэх, коронавирусын халдвараас сэргийлэх зөвлөгөө, зөвлөмж, нөлөөллийн ажлыг цахим орчноор зохион байгуулж, баталгаатай эх сурвалжийн мэдээллийг түгээн ажиллах зорилгоор амны хаалт зүүх, гараа угаахын ач холбогдлыг сурталчилсан зөвлөмжийг хэвлэн айл өрх, аж ахуй нэгжүүдэд тарааж, дасгал хөдөлгөөн, цахим сургалт, амны хаалт зүүх, коронавирусаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, постерыг байгууллагын болон олон нийтийн зарын цахим хуудсанд байршуулж, мэдээллийг хүргэж байна.

Охид эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийг эсэргүүцэх, таслан зогсоход нийгмийн ойлголт хандлага, мэдлэгийг нэмэгдүүлэх, орон нутагт иргэдийн утга учиртай оролцоог нэмэгдүүлэх, улмаар хүчирхийллийн эсрэг хамтдаа тэмцэх иргэдийн оролцоог бэхжүүлэх зорилгоор “Нэг тэрбумаараа тэмцье-2020” бидний дуу хоолой арга хэмжээг олон нийтийн сүлжээ, цахим хуудсанд байршуулан ажиллалаа.

Боловсрол, соёл урлагийн чиглэлээр: БСШУСЯ-ын сайдын А/659 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн спортын секцийн сургалтын ерөнхий бүтэц, сургалтын хөтөлбөрийн жишиг агуулгын төлөвлөлтийг боловсруулан аймаг орон нутагт түгээмэл хөгжиж байгаа болон цаашид шинээр хөгжүүлэх спортын төрлүүдийн сургууль дундын секцийн бодлого төлөвлөлтийг боловсруулан ажиллалаа. Биеийн тамирын багш нарт онолын мэдлэг, мэргэжил арга зүйн зөвлөмжийг боловсрууллаа.

12 дугаар ангийг өдрөөр 595, дүйцсэнээр 46, Нийт 641 хүүхэд төгсөнө. Тайлант хугацаанд нийт 424 хүүхэд бүртгүүлсэн бөгөөд бүртгэлийн явц 68.9 хувьтай байна. Бүртгэл эхэлснээс хойш 148 иргэнд ЭЕШ-ын талаар мэдээлэл өгч, алдаатай болон буруу бүртгэгдсэн 7 хүүхдийн мэдээллийг залруулан бүртгэлээ. Боловсролын үнэлгээний төвөөс өгч байгаа зөвлөмж мэдээллийг сургуулиудад хүргүүлэн, сурагчдад мэдээлэл өглөө. ЭЕШ-д бэлтгэх цахим групп үүсгэж, судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүд, багш нартай хамтран хичээл, тест, зөвлөгөөг байршуулж, хүүхдүүдийг бэлтгэж мэдээллээр ханган ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургуулийн теле хичээлд хамрагдалтын судалгааг хийж, теле хичээлд хамрагдалт өмнөх 7 хоногоос нэмэгдэж байгаа бөгөөд багш нар сурагчидтай холбоо барьж, хичээлээ бичиж тэмдэглэсэн, даалгавраа хийсэн эсэхийг цахимаар шалгахад нийт сурагчдын 73.6% нь теле хичээлдээ хамрагдсан үзүүлэлттэй байна.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан өндөр настан 94, тахир дутуу 18, тэжээгчээ алдсан 3 хүн, нийт 115 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Сайн дурын даатгалд 41, 0-3 насны хүүхдээ асарч буй эх 11 хүнийг тус тус хамрууллаа. Эрүүл мэндийн даатгалд 485 иргэний 20785.3 мянган төгрөгийг төвлөрүүллээ.

Тэтгэмж тогтоолт, олголтоор хөдөлмөрийн чадвар түр алдсан 44 хүнд 11245.2 мянган төгрөг, Жирэмсэн, амаржсаны 58 хүнд 72631,2 мянган төгрөг, оршуулгын тэтгэмжид 20.0 сая төгрөгийг тус тус тогтоож, олголоо. Ажилгүйдэл шинээр 14 хүнд 24587.2 мянган төгрөг тогтоож, 16 хүнд 16374,4 мянган төгрөг олголоо.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын цахим хуралд 186 хүн хамрагдсанаас шинээр-19 хүн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, 3 хүн цуцлагдаж 164 хүн сунгагдлаа.

Хөдөлмөр, халмжийн чиглэлээр: 2020 оны 3-р сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 850 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 55,0% нь бүрэн дунд, 22,0 % нь дээд, 9,6 % нь техникийн мэргэжлийн боловсролтой байна. Мөн бүртгэлтэй ажилгүй иргэдийн 34,8% нь 25-34 насны залуучууд, 18.5 хувь нь 15-24 насны залуучууд тус тус эзэлж байна. Тайлант сард аймгийн хэмжээнд 11 иргэн ажлаасаа чөлөөлөгдөж, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авсан байна. 2020 оны 3-р сард Хөдөлмөрийн хэлтэст нийт 4 аж ахуй нэгж байгууллагаас 43 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирсэн байна. Ажлын байрны зуучлах үйлчилгээний дагуу 33 иргэнийг зуучлан байнгын ажлын байраар хангасан байна.

Нийгмийн халамжийн сангийн чиглэлээр: 2020 оны 03 дугаар сарын нийгмийн халамжийн сангаас халамжийн тэтгэвэр 1343 иргэнд 249.7 сая, нөхцөлт мөнгөн тэтгэмж 952 иргэнд 82.3 сая, амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 857 иргэнд 67.8 сая, ахмад настны хөнгөлөлт тусламж 43 иргэнд 10.9 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж 85 иргэнд 3.8 сая, жирэмсэн эхийн тэтгэмж 524 иргэнд 19.4 сая, алдарт эхийн одонтой эхийн тэтгэмж 13 эхэд 1.3 сая, насны хишгийн мөнгөн тэтгэмж 10 эхэд 0.6 сая, өрх толгойлсон эхийн тэтгэмж 117 иргэнд 48.4 сая, ихэр хүүхдийн тэтгэмж 1 өрхөд 2.0 сая,

цалинтай ээжийн тэтгэмж 2465 иргэнд 121.1 сая, алдар цолтой ахмадын хөнгөлөлт 30 иргэнд 4.5 сая, нийт 611.8 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлээд байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн хүрээнд: Хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамруулах хүсэлт гаргасан 19 өрхийг амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрууллаа. Хүсний эрхийн бичгийн үйлчилгээ авах босго онооноос доош үнэлэгдсэн Тайшир сумын 3-р багийн нэг өрхийг тус сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн. Мөн шинэ төрсөн 88 хүүхдийг мэдээллийн санд бүртгэж хүүхдийн мөнгө авах нөхцөлийг бүрдүүллээ.

АРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Тус аймгийн Тайшир сумын Овооно хар орчмын аргаль хонь, Халиун сумд нутагшуулж байгаа илий, Монгол бөхөнгийн тархац нутаг болох Хөхморьт, Баян-Уул сумд тус бүр 50 боодол өвс тавьж биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгууллаа.

Сумдад биотехникийн арга хэмжээ зохион байгууллаа.

Хөхморьт сумын ундны худагт цэвэршүүлэх цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулах, худгийн барилга байгууламжид дулаалга, засвар хийх, худгийн эрүүл ахуйн бүс тогтоон, хашаа хамгаалалт хийж тэмдэгжүүлэх, өвлийн улиралд доголдолгүй ажиллах, байгальд ээлтэй, эрүүл ахуйн шаардлага хангахуйц байдлаар халаалт дулааны асуудлыг шийдвэрлэх, айл өрх, хүүхэд багачуудад ундны усыг тасралтгүй хүргэх, хүртээмжийг сайжруулах зорилгоор санхүүжилтийг НҮБ-ын Хүүхдийн сан, БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (KOICA) болон, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлал нийт 116.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Орон нутгийн өмчийн газартай хамтран худалдан авах ажиллагааг зохион байгуулан тендерт шалгарсан Баялаг говь ХХК-аар хүчин чадал бүхий шүүлтүүртэй ухаалаг худгийг суурилуулан ашиглалтад орууллаа.

Цэвэршүүлэх цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулах ажлыг зохион байгууллаа

Тус аймгийн аймгийн Дэлгэр сумын Баянхонгор багийн нутагт малчны хотны ойролцоо цоохор ирвэс ирсэн дуудлагын дагуу газар дээр нь очиж сумын Засаг дарга, БОХУБайцаагч, байгаль хамгаалагч, хэсгийн төлөөлөгч нартай хамтран ажиллаж тухайн байршлаас 18 км газарт харгалзан тууж уулын бүсрүү ойртуулж хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулан малчид, ард иргэдэд холбогдох хууль тогтоомж, анхааруулга санамжийг өгч ажиллалаа.

Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 17 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэг тус аймгийн уул уурхайн ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой баримт бичигт төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс 20-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, үнэлэлт дүгнэлт, байгаль орчны нөхөн сэргээлтийн баталгаа хөрөнгийн байршуулалт, байгалийн нөөц ашигласны төлбөрийн барагдуулалт, бичил уурхайн холбогдох баримт бичигтэй болон шаардлагатай мэдээ мэдээлэл, судалгаатай танилцлаа.

Аймгийн хэмжээний тахиж шүтдэг уул, ус, овооны судалгааг нэгтгэн гаргаж БОАЖЯ-нд хүргүүллээ. Судалгаагаар аймгийн хэмжээнд 137 тахиж шүтдэг уул, ус, овоо байгаа гэсэн дүн мэдээ гарлаа.

3 дугаар сард Есөнбулаг сумын иргэн Ё.Хатанбаатарын хүсэлтийн дагуу Солонго хороололд шинээр баригдах худалдаа үйлчилгээний төвийн төсөлд байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийн, мэдээллийн санд байршууллаа.

АРВАН НЭГ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар: БНХАУ болон дэлхийн бусад улс оронд шинэ коронавирусийн тархалт эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан жолооч нарыг эрсдэлээс хамгаалах зорилгоор хятад болон монгол хэлээр зөвлөмж боловсруулан Алтайн хүдэр ХХК-д 2020 оны 03 сарын 11-ний өдрийн 03/148 дугаар албан бичгээр хүргүүлж, нийт 89 тээврийн хэрэгсэлд байршуулж, улс хоорондын ачаа тээвэрлэлтийн бэлтгэл ажлыг бүрэн хангуулан ажиллалаа.

Хоёр. Боловсрол, соёл, эрүүл мэнд, хүнсний чанар, эрүүл ахуйн бодлогын хүрээнд: БНХАУ болон дэлхийн бусад улс оронд шинэ коронавирусийн тархалт эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан уг халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор соёл, урлаг, шашны байгууллагуудад олныг хамарсан уулзалт, сургалт, семинар, ёслол хүндэтгэл, урлаг, спортын арга хэмжээ, шашин номын хурал, цуглаан, зан үйл хийхгүй, иргэдийг оролцуулахгүй байх талаар 2 төрлийн зөвлөмж сэрэмжлүүлэг гарган аймгийн төвийн нийт 4 газарт хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тус аймагт сүм хийдийн үйл ажиллагаа түр зогссон.

Хүнсний чанар, стандартын хяналтаар: Цагаан сарын баярын урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хамрагдсан 15 хүнсний худалдааны газар гүйцэтгэлийн хяналт хийж зөрчил гаргасан нэг иргэнийг 100,0 төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ авч, барагдууллаа.

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг хүнсний үйлдвэрийн судалгаа, Хүнсний нөөцийн судалгааг гаргаж МХЕГ-т цахимаар хүргүүллээ.

Эмчилгээний чанар, Эм, биобэлдмэл, Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтаар: Зам тээвэр хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн дарга, Мэргэжлийн Хяналтын Газрын дэд дарга нарын баталсан “Коронавируст халдварын үед орон нутгийн нислэгээр зорчих зорчигчдын эрүүл мэндэд хяналт тавих түр заавар”-ын дагуу эмчилгээ, эрүүл ахуй, эм биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч нар Говь-Алтай-Улаанбаатар, Улаанбаатар-Говь-Алтай чиглэлд зорчсон 276 зорчигчдын эрүүл мэндийн байдалд хяналт, тандалт хийлээ.Тандалтаар сэжигтэй тохиолдол илрээгүй болно.

Мал эмнэлгийн хяналтаар: Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хүрээнд аймгийн хэмжээнд хийж хэрэгжүүлж байгаа ажил болон мал эмнэлгийн хяналтын чиглэлээр үүссэн нөхцөл байдлын талаар орон нутгийн “Алтай” радио, “MNTY” телевизэд мэдээлэл хийлээ.

Аймгийн Засаг даргын 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн А/136 дугаар захирамжийн дагуу Есөнбулаг сумын Оргил багт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага 4, аж ахуйн нэгж 1, банкны 2, худалдаа үйлчилгээний 5, хоол үйлдвэрлэлийн 2, нийт 14 объектод коронавирусээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж байгаа ажилтай танилцаж, үүрэг чиглэл өглөө.

МХГ-ын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Есөнбулаг сумын мал аж ахуйн чиглэлээр /Рашаант багт/ үйл ажиллагаа явуулж байгаа “Энгүүн бишрэлт” ХХК-ийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхэд 450 оноо буюу 40,2%-аар дунд эрсдэлтэй үнэлэгдэж, хууль тогтоомжийн хэрэгжилт 56,0%-тай байна.

Боловсрол, соёлын хяналтаар: Улсын онцгой комиссын шийдвэр, аймгийн Засаг даргын захирамжийн дагуу Цагдаа, Есөнбулаг сумын Засаг даргын захирагчийн албатай хамтран Алтай хотын 11 байгууллагат урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ.

Гурав. Байгаль орчин, уул уурхай, хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгаалал, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

Хөдөлмөр, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтаар: Үйлдвэрлэлийн ослыг бууруулах, эрсдэлтэй хүчин зүйлийн нөлөөллийг судалж, ажлын байрны эрсдэл үнэлэн аюул ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 16 заалт бүхий зөвлөмж боловсруулан, их эрсдэлтэй үнэлэгдсэн 12 аж ахуйн нэгжид хүргүүлээ.

Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 2 аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гаргахаас урьдчилан сэргийлэх, коронавирус-ээс ажилчдыг хамгаалах чиглэлээр 12 заалт бүхий зөвлөмж боловсруулан хүргүүлээ.

Авто замын хяналтаар: 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн Авто замын хөдөлгөөн нээсэнтэй холбогдуулан Алтай хотыг дайран өнгөрч байгаа улсын чанартай авто замуудын бэлэн байдалд хяналт шалгалтыг гүйцэтгэж, авто замын хучилтад гарсан эвдрэлийг засах, ус зайлуулах байгууламжийн цас мөс, хог, сэг зэмийг цэвэрлэх, эвдрэлд орсон гүүрийг тойрч гарах түр замын даланг засварлах, тэмдэг нэмж суулгах талаар хариуцагч байгууллагад үүрэг өгч, зөрчлийг арилгуулж ажиллалаа. Хяналт шалгалтад улсын чанартай 456 км, орон нутгийн чанартай 24 км авто зам, замын байгууламж хамрагдлаа.

Дөрөв . Нэгдсэн лаборатори:

Лабораторид 2 аж ахуйн нэгж, 4 байгууллагаас ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүний 1 сорьцонд 7 үзүүлэлт, ариутгалын бодисын 1 сорьцонд 1 үзүүлэлт, ундны усны 8 сорьцонд 56 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг хийлээ. Үүнээс ундны усны 6 сорьцонд 8 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй байна. Шинжилгээний төлбөр 30000 төгрөгийг бүрэн төвлөрүүлээ.

АРВАН ХОЁР. СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ТАЛААР:

Есөнбулаг сум: “Алтай хот”, “Нийгмийн ажилтнууд” зэрэг цахим хуудсуудаар дамжуулан иргэдэд өвчлөл, урьдчилан сэргийлэлтийн чиглэлээр 28 зөвлөгөө мэдээлэл хүргэн ажиллаж байна. Байгууллагын бүх өрөө тасалгаанд их цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлт хийн, албан хаагчдад гар ариутгагч бодис өгч эрсдэлийг буурууллаа.

Зорилтот бүлгийн 192 өрхийн гишүүдийг витаминжуулалтад хамруулан дархлааг нь дэмжих ажлыг зохион байгууллаа. Цаг үеийн байдалтай холбогдуулан 2400 ширхэг амны хаалтыг 10 багийн зорилтот бүлгийн өрхүүдэд түгээлээ

Алтай сум: Эрүүл мэндийн төвөөс төрийн байгууллагууд болон дэлгүүр үйлчилгээний цэгүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтийг 2 удаа хийлээ.

12 дугаар ангийн сурагчдад хэсэгчилсэн байдлаар болон гэрээр нь даалгавар, шалгалтад бэлтгэх тест, материалаар ханган бэлтгүүлж байна.

Багш, ажилчид нэг нэг бүтээлч ажил өрнүүлэн гарын доорх материалуудаар 30 гаруй төрлийн бүтээлч ажил хийж хүлээлгэн өглөө.

Бугат сум: Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед ажиллах ажлын заавар зөвлөгөөг төрийн албан хаагчдад мэдээллээ. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэн тодорхой хугацаанд хөл хорио, хязгаарлалт тогтоосонтой холбогдуулан Эрүүл мэндийн төвтэй хамтран халдваргүйтгэл, ариутгалыг бүх байгууллагын өрөө тасалгаанд хийлгэж, хаалганы бариул, албан өрөөнүүдийг ариутгалын бодисоор байнга угааж, цэвэрлэж хэвшээд байна.

Дэлгэр сум: (COVID-19)-ын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан халдвар, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, тараах материалыг цаг алдалгүй ЭМЯ-ны цахим хуудсаас авч, мэдээллийг сумын иргэдэд цахимаар зөвлөгөө өгч ажиллаж байгаа бөгөөд “Таны хайхрамжгүй орхисон нэг хором” хүүхдийг насан туршийн эрсдэлд оруулна уриалга нь доор зөвлөмж, сэрэмжлүүлэг болон шторкыг иргэдэд цахимаар хүргэн ажиллаж байна. Мөн улирал солигдож байгаатай холбогдуулан хачигт халдвараас урьдчилан сэргийлэх заавар зөвлөгөөг иргэдэд цахимаар хүргэн ажиллаж байна.

Сумын номын сангаас гэрээсээ гаралгүйгээр интернет ашиглан “Цахим ном унших” аян эхлүүлээ. Аяны хүрээнд цахим хуудсанд 7 хоног бүр 2-3 ном байршуулж иргэдэд цахимаар хүргэн ажиллаж байна.

Тонхил сум: Тус сумд 2020 оны 03 дугаар сарын 20 ны өдөр ойр ойрхон давтамжтай дөрвөн удаагийн газар хөдлөлт боллоо. Өргөрөг уртрагийн хэмжээг сумын газрын зураг дээр нарийвчлан тодруулахад Бүс-Уул багийн нутаг Хатан худаг, Бөөн чулуут гэдэг газруудад гол газар хөдлөлт явагдсан байна. Мэдээллийг хүснэгтээр харуулбал:

д/д	Хөдлөлтийн дугаар	Цаг хугацаа	Уртраг, өргөрөг	Сумын төвөөс зай	Магнитутын хэмжээ	Тайлбар
1	Эхний удаа	11.03.22сек	ө46.06:у 94.07	30км	5.8	
2	Хоёрдахь удаа	11.04.08 сек	ө46.05:у94.04	30км	3.6	
3	Гурав дахь удаа	11.55.03 сек	ө46.06:у94.07	30км	4.5	
4	Дөрөв дэх удаа	12.08.55 сек	ө46.07:у94.06	30км	4.1	

Маш ойрхон давтамжтай хөдөлж сумын төвийн иргэд бүгдээрээ мэдэрсэн төдийгүй сумын төвөөс 28-65 км алслагдсан багийн иргэдэд мэдрэгдсэн байна. ХААН банк, Цаг уурын станцын барилгуудад шинээр цууралт үүсээгүй байлаа. Бусад зургаан барилгад шинээр хана цуурч гэмтсэн байна. Үүнд: ЗДТГ-ын барилгын дотор хана, ЕБС-ийн гадна, дотор хана, ЭМТөвийн гадна хана, Сургуулийн дотуур байрны дотор хана, Цэцэрлэгийн барилгын дотор хана, Соёлын төвийн барилгын гадна, дотор хана зэрэг болно.

Цогт сум: Дэлхий нийтээр коронавирусийн халдвар тархаж байгаа, өндөржүүлсэн бэлэн байдал зарласан онцгой энэ үед сумын иргэдийнхээ аюулгүй, цэвэр цэмцгэр орчинд амьдрах боломжийг бүрдүүлэх зорилгоор хог цэвэрлэгээний фэйсбүүк аян өрнүүлж, нийтийн эзэмшлийн зам талбайн хог цэвэрлэгээг зохион байгууллаа. Бүх нийтийн хогийн цэвэрлэгээнд 2 машин үйлчилж, 5 албан байгууллага, 7 аж ахуйн нэгж, 260 гаруй иргэд идэвхтэй оролцож, 5 тн орчим хогийг цэвэрлэн хогийн цэгт хүргэлээ. Сумын Засаг даргын шийдвэрээр “Сумын шуурхай штаб”-ыг байгуулан, худалдаа, үйлчилгээний газруудын ариун цэвэр, хүнсний аюулгүй байдалд хяналт шалгалт хийж, иргэн, аж ахуйн нэгжүүдэд шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг

давхардсан тоогоор 1968 иргэнд өгч, сумын хэмжээнд 12 албан байгууллага, 424 өрхийн бие засах газар, бохирын цооногт ариутгал халдвартгүйтгэлийн ажлыг хийж, зөвлөгөө мэдээлэл өглөө.

Шарга сум: Говь-Алтай аймгийн Шарга сумын Баянгол багийн Сумын сайн малчин Чойжилын Түмэннастын “Төхөм тунгалагийн хүрэн” үүлдрийн тэмээн сүргийн хүрэн ингэ нь 03 дугаар сарын 11-ний өдөр 4 дэх удаагаа ботголж эр, охин ихэр ботго төрсөн онцлог үйл явдал боллоо.